

## ӨРХИЙН САНХҮҮГИЙН ЧАДАМЖИД СУУРИЛСАН ҮР АШГИЙГ ҮНЭЛЭХ НЬ: ОРХОН АЙМГИЙН ЖИШЭЭН ДЭЭР

Э.Жавхлан\*, Т.Ууганбаяр\*\*

**Хураангуй:** Судалгааг Орхон аймгийн 597 өрхийн түүвэрт үндэслэн HFWI (Household financial wellness index) аргачлалыг ашиглан өрхийн санхүүгийн чадамжийг тооцоход судалгаанд хамрагдсан өрхүүдийн 23.1% нь санхүүгийн чадамжгүй буюу санхүүгийн байдал “хямарсан” болон “тогтворгүй” гэсэн үр дүн гарсан нь Монголын үндэсний статистикийн хороо & Дэлхийн банк (2016) хамтарсан “Ядуурлын дүр төрх -2016” судалгааны үр дүнтэй нийцэж байсан.

Өрхийн санхүүгийн чадамж ямар ангилалд байхаас хамааран өрхийн гишүүдийн боловсролын түшин, албан тушаал, ажилласан жил, хадгаламж, даатгал, төсвийн ашиг, алдагдал зэрэг үзүүлэлтүүд харилцан адилгүй нөлөөлдөг байна. Мөн одоогийн эдийн засгийн нөхцөл байдалд өрхүүдийн санхүүгийн чадамж сайжрах магадлал муу байгаа нь үнэлгээний үр дүнгээс харагдаж байна.

Өрхүүдийн санхүүгийн үр ашгийг үйлдвэрлэлийн үр ашгийн шинжилгээний параметрийн бус DEA аргачлалаар тооцоолсон. Өрхүүдийн санхүүгийн үр ашгийг DEA аргачлалаар үнэлэхэд дундаж утга 0.63 гарсан нь хангалттай үзүүлэлт биш боловч өрхийн гишүүдийн боловсролын түвшин, ажлын туршлага, албан тушаал дээшилснээр зээлийн ашиглалт, өрийн удирдлага сайжирч, орлогоо оновчтой хуваарилан, хэрэглээний зан төлөвт эерэг өөрчлөлтийг бий болгох замаар үр ашгийг нэмэгдүүлэх боломжтой байна.

**Түлхүүр үгс:** Өрхийн санхүү, санхүүгийн үр ашиг, санхүүгийн чадамж, технологи

**Abstract:** The survey was based on the 597 household sample of Orkhon province based on the HFWI (Household Financial Wellness Index) methodology that made by the university of South Africa based on household physical capital, human capital, capitalized capital and social capital. 23.1% of the households surveyed in Orkhon province had the results of “financial crisis” and “unstable” financial results in line with the results of the Joint National Statistical Office of Mongolia and the World Bank.

Assess HFWI methodology estimated household financial capacity factor lojit design and analysis identified families credibility and financial capacity and the factors influencing migration categories.

Depending on the category of financial capacity of the household, the educational background, position, years of employment, savings, insurance, fiscal surplus and deficit affect the household members. In addition, the results of the evaluation show that the current financial situation of households

\* МУИС-ийн Бизнесийн сургууль, (E-mail) javkhaasankhvv@gmail.com

\*\* МУИС-ийн Эрдэнэт сургууль, (E-mail) t.uugaa0907@gmail.com

is less likely to improve the financial capacity.

While the average value of households is assessed as DEA, an average value of 0.63 is not enough, however, it is possible to increase efficiency by improving the level of education, work experience and position of the household members by improving loan utilization, debt management, rational distribution of income and positive behavioral patterns will.

It is possible to measure the effectiveness of the program by re-measuring the financial capacity and efficiency of the household, after the implementation of the “Medium-Term Program to Increase Public Financial Knowledge”

**Key words:** Household finance, finance efficiency, financial capacity, technology

## Удиртгал

Улс орны хөгжлийг дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөөр (нэг хүнд ногдох орлогын өсөлт) хэмждэг эдийн засгийн өсөлт нь нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, шинжлэх ухаан технологийн хөгжил дэвшлийн үр дүнд экологийн болон нийгмийн сөрөг (тухайлбал, усан болон агаар орчны цэвэр ариун байдал, агаар мандлын тогтвортой байдал, байгалийн нөөц баялаг, ногоон дэлхийг сүйтгэх, орлогын ялгаатай байдал, өрхийн аз жаргал, эрүүл мэнд зэрэг) үр дагавруудыг бий болгож байна. Тиймээс сүүлийн жилүүдэд тогтвортой эдийн засаг, ногоон эдийн засаг гэх мэт өсөлттэй байгаа эдийн засгийн амьдрах чадварыг нэмэгдүүлэх олон аргыг хэрэглэх болжээ.

Урт хугацааны тогтвортой, найдвартай эдийн засагт хүрэхийн тулд аливаа улсын өрхийн амьжиргааны түвшин, ядуурлын түвшин, хүний хөгжлийн индекс, аз жаргалын индекс, өрхийн санхүүгийн чадамж зэрэг нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийг тооцож төр засгийн зүгээс бодлогын баримт бичиг боловсруулан, үндэсний хэмжээний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн иржээ.

Сүүлийн жилүүдэд Их Британ, Өмнөд Африкийн улсуудад өрхийн санхүүгийн чадамжийг санхүүгийн сайн сайхан байдлын индексээр тооцож, өрхүүдийн амьжиргаа, амьдралын чанарын асуудлыг хөнддөг болжээ.

Өрхийн санхүүгийн чадамжийг санхүүгийн сайн сайхан байдлын индексээр тооцох аргачлалыг (Cantril M. , 2010) (Cantril H. , 1965) анх хөгжүүлж, өрхүүд санхүүгийн байдалдаа хир сэтгэл ханамжтай байгаагаар нь санхүүгийн чадамжийг илэрхийлж байсан бол (Strumpel, 1976) өрхийн тэргүүний орлого, хадгаламжтай холбоотой ойлголтуудыг нэмж өргөжүүлсэн юм. Үүний дараа (Garman & Porter, 1993) нар өрхийн санхүүгийн сайн сайхан байдлын тухай ойлголт, үзэл баримтлал, үнэлгээний аргачлалыг боловсруулан туршиж байжээ.

Үйлдвэрлэлийн салбарын үр ашгийн шинжилгээнд ашиглагддаг байсан параметрийн бус детерминистик болон параметрийн стохастик загваруудыг орчин үед банк санхүү, иргэний агаарын тээвэр, боловсрол, харилцаа холбоо, өрхийн санхүү зэрэг салбаруудын үр ашиг, бүтээмжийн судалгаанд ихээр ашиглах болсон.

Үйлдвэрлэлийн үр ашгийн шинжилгээний үндэс суурь болсон тодорхойлолтыг Коортманс.Т (1951) математик талаас нь анх удаа тайлбарласан бөгөөд “Үйлдвэрлэгч нь хэрвээ, зөвхөн зарим орцыг илүү их хэрэглэхгүйгээр илүү гарцыг бүтээх боломжгүй болсон үед технологийн үр ашигтай байна” гэж тодорхойлжээ.

Эдийн засгийн үр ашгийн шинжилгээний талаар хийгдсэн орчин үеийн судалгааны ажлууд нь Farrell.M (1957)-ын бүтээлтэй салшгүй холбоотой бөгөөд түүнээс эх сурвалжаа авсан байдаг. Farrell.M (1957) нь үйлдвэрлэлийн нэгжийн нийт үр ашгийг технологийн үр ашиг болон хуваарилалтын үр ашиг гэсэн бүрдэл хэсгүүдэд хуваарилах аргыг анх гаргасан байна.

Эндээс үзэхэд хөгжингүй орнууд 1965 оноос эхлэн өрхүүдийн санхүүгийн байдлыг бэхжүүлэхэд анхаарлаа хандуулж, санхүүгийн чадамж, үр ашгийн үнэлгээ хийхийн тул өрхийн санхүүгийн сайн сайхан байдлын индексийг тооцох аргачлалыг боловсруулан, микро болон макро хүчин зүйлсээс хэрхэн хамаарч байгаа судлан иржээ. Тухайлбал ханшийн уналт, инфляци, гадаа худалдаа, ажилгүйдэл, эдийн засгийн хямрал зэрэг нь өрхийн санхүүгийн байдалд хэрхэн нөлөөлдийг тодорхойлсноор төрийн бодлого иргэдэд хүртээмжтэй, бодит үр дүнгээ өгдөг байна.

Манай орны хувьд өрхийн санхүүгийн сайн сайхан байдлын индексийг тооцох, үр ашгийг үнэлэх, нөлөөлөх хүчин зүйлсийн талаар хийгдэж байсан судалгаа шинжилгээний ажлууд хомс бөгөөд өрхийн төсөв зохиох арга зүйн, өрхийн амьжиргааны түвшний талаар судалгаа, шинжилгээний ажлууд хэвлэгдэж байсан бол Монгол улсын засгийн газраас 2012-2015 онд “Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр<sup>3</sup>”-ийг батлан хэрэгжүүлж, үүний хүрээнд өрхийн амьжиргаа, амьдралын чанарыг “орлогыг орлуулан тооцох арга”-аар өрхийн амьжиргааны түвшинг тогтоож байсан түүхтэй.

Манай улс 1935 онд 198792 өрхтэй байсан бол 2018 онд 869849 болж өдгөө 83 жилийн хугацаанд 4,37 дахин нэмэгджээ. 2016 оны жилийн эцсээр нийт хүн амын тоо 3,119,935 хүнд хүрч, нэг өрхөд 3-4 хүн ногдож байна. Хүн амын тоо сүүлийн жилүүдэд хурдацтай өсч (жилд дунджаар 63047 хүнээр өсдөг) байгаа тул нийгэмд өрх, гэр бүлийн аз жаргал, стресс бухимдлыг бий болгон гэр бүл салаалт, хүүхэд өнчрөх, хүүхдийн болон өрхийн гишүүдийн

<sup>3</sup> нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т заасны дагуу ҮСХ-ны дарга, Нийгмийн хамгааллын сайд хамтран 2010 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 58/36 дугаар тушаалаар баталсан

боловсрол муудах, архидалт, гэмт хэрэг, эмзэг бүлгийнхнийг бий болгох зэрэг олон сөрөг үр дагаврыг бий болох хандлагатай тул бид өрхийн амьжиргаа, ядуурлын эсрэг тэмцэх зорилгоор өрхийн санхүүгийн чадамжийг сайжруулах зорилгоор төрийн зүгээс бодлого боловсруулан, үндэсний хэмжээний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажиллах нь зүйтэй юм.

Сүүлийн жилүүдэд Монголбанкнаас санаачлан өрхийн төсөв, санхүүгийн боловсролын талаар сургалт хийж, эрдэм шинжилгээний ажлыг дэмжиж, 2017 оны 10 сараас “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд “санхүүгийн боловсрол”-ын аяныг санаачлан зохион байгуулж байгаа нь өрхүүдийг санхүүгийн үйлчилгээтэй холбоотой мэдлэг, мэдээллээр хангах, аливаа санхүүгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, оновчтой шийдвэр гаргадаг байх, хувийн болон өрхийн санхүүгээ удирдах зөв дадал, хэвшилтэй болж өрхүүд орлогоо оновчтой хуваарилдаг болсноор эдийн засаг тогтвортой байж, цаашдаа хадгаламж, хөрөнгө оруулалт өсч, эдийн засгийн өсөлт бий болох таатай орчин нөхцөл бүрдэх юм.

**Тиймээс энэхүү судалгааны ажлаар Орхон аймгийн өрхүүдийн санхүүгийн чадамжийг тооцож, санхүүгийн үр ашгийг үнэлэхийг зорилоо.**

Энэхүү судалгаа нь өрхийн санхүүгийн чадамжийг тооцож, санхүүгийн үр ашгийг үнэлэх замаар өрхүүдийн санхүүгийн чадамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн болно. Өрхүүд санхүүгийн хувьд ямар түвшинд байгааг (1) өрхүүдийн санхүүгийн чадамжийг түүвэр судалгаанд үндэслэн тооцох, (2) өрхүүдийн санхүүгийн үр ашгийг DEAR болон аргачлалаар үнэлсэн нь бусад ийм төрлийн судалгааны ажлаас ялгагдах юм.

**Тоон өгөгдөл.** Эх олонлогийг тодорхойлохдоо Орхон аймгийн Баян-Өндөр сумын нийт хүн амын тоонд үндэслэн Баян-Өндөр сумын 21 багаас санамсаргүй түүврийн аргаар 597 өрх түүвэрлэн авсан. Түүвэрлэлтийг хийхдээ 95%-ийн магадлалын түвшинд, алдааны хязгаарыг 4% байна гэж үзсэн.

**Хүснэгт 1.** Баян-Өндөр сумын 21 багаас судалгаанд хамрагдсан өрхүүд

№	Баг	Өрхийн тоо	Хувь	№	Баг	Өрхийн тоо	Хувь
1	Зэст баг	28	4.7%	12	Булаг баг	21	3.5%
2	Оюут баг	34	5.7%	13	Баянцагаан баг	28	4.7%
3	Уурхайчин баг	36	6.0%	14	Говил баг	23	3.9%
4	Хүрэнбулаг баг	27	4.5%	15	Рашаант баг	32	5.4%
5	Уртбулаг баг	23	3.9%	16	Эрдэнэ баг	31	5.2%

6	Согоот баг	30	5.0%	17	Баянбулаг баг	20	3.4%
7	Дэнж баг	31	5.2%	18	Их залуу баг	35	5.9%
8	Бүрэнбүст баг	22	3.7%	19	Даваат баг	32	5.4%
9	Шанд баг	34	5.7%	20	Яргуйт	31	5.2%
10	Наран баг	21	3.5%	21	Уртын гол	32	5.4%
11	Цагаанчулуут баг	26	4.4%	22	<b>Нийт</b>	<b>597</b>	<b>100%</b>

Судалгаанд хамрагдсан нийт өрхүүдийн 55.4 хувь нь гэр хороолол, 43.6 хувь нь орон сууцны хороолол, 1.0 хувь нь хувийн хауст амьдардаг ба эзэмшлийн хувьд 90.5 % нь хувийн эзэмшлийн, 3.2 % нь зээлийн хөрөнгөөр санхүүжүүлсэн, 6.4 % нь түрээсийн болон бусад орон сууцанд амьдарч байна. Ам бүлийн тооны хувьд 42.9 % нь 3 хүртэл, 56.1 % нь 4-6 хүртэл, 1.0 % нь 7 буюу түүнээс дээш гишүүнтэй өрхүүд судалгаанд хамрагджээ.

### Судалгааны арга зүй

Өмнөд Африкийн их сургуулиас өрхийн санхүүгийн чадамжийг тодорхойлох санхүүгийн сайн сайхан байдлын индексийг боловсруулан 2011 оноос хойш судалж, хөгжүүлэн ирсэн. Уг аргачлалын дагуу Өмнөд африка улсын жишээ дээр сүүлийн 7 жил судалгаа хийж, судалгааны тайланг олон нийтэд мэдээлэлж байна. Жил бүрийн судалгааны тайлан дээр өрхийн санхүүгийн чадамжийг HFWI индексээр тооцож, Санхүүгийн байдал хүндэрсэн буюу хямарсан, санхүүгийн байдал тогтворгүй, Санхүүгийн байдал боломжийн, Санхүүгийн байдал сайн гэсэн 4 ангилалд авч үзэн эдгээр өрхүүдийн санхүүгийн байдалд макро болон микро хүчин зүйлс хэрхэн яаж нөлөөлж байгааг тайлбарласан байдаг.

Household financial wellness index (HFWI) нь өрхийн санхүүгийн чадамжийг тооцохдоо өрхийн биет капитал, хүмүүн капитал, нийгмийн капитал, байгалийн капитал, хөрөнгийн капиталуудаас хамааруулан тооцдог аргачлал юм.

**Өрхийн биет капитал:** Өрхийн хөдөлмөр эрхлэлт болон бусад эх үүсвэрээс орлого олох чадварыг илэрхийлдэг ба тухайн орлогыг зарцуулж буй зардлын төрлүүдээр тодорхойлогдоно.

**Өрхийн хүмүүн капитал:** Тухайн өрхийн гишүүдийн хувь хүний хөгжлийг илэрхийлдэг.

**Өрхийн нийгмийн капитал:** Өрхийн гишүүдийн нийгмийн эрх мэдлийн түвшин, нийгэмд эзлэх байр суурийг илэрхийлнэ.

**Өрхийн байгалийн капитал:** Хувь хүний амьдарч байгаа байгаль орчны чанарыг илэрхийлнэ.

**Өрхийн капиталжсан хөрөнгө:** Өрхийн цэвэр баялгийг илэрхийлнэ.

Өрхийн нийт хөрөнгөөс нийт өр төлбөрийг хасах замаар тооцно.

Уг капиталыг ашиглан дараах үр дүнгүүдийг илэрхийлдэг.

- ❖ **Санхүүгийн байдал хүндэрсэн буюу хямарсан ( $0 < \varpi < 30\%$ )**  
Өрхийн санхүүгийн хүндрэлтэй байдал нь нэлээд гүнзгийрсэн. Хүндрэлийг сайжруулахад гадны тусламж, дэмжлэг шаардлагатай байгааг илэрхийлнэ.
- ❖ **Санхүүгийн байдал тогтворгүй ( $30\% < \varpi < 60\%$ )**  
Өрхийн санхүү нь хямралын байдалд хүрээгүй ч санхүүгийн хувьд эрүүл бус байдалд байгаа. Энэ байр суурь нь санхүүгийн хувьд тогтворгүй байдлыг илэрхийлэх ба тааламжгүй үйл явдал болон буруу шийдвэрүүд нь санхүүгийн хямралын байдалд маш амархан шилжих магадлалтай. Хэдий тийм ч санхүүгийн чадамжиа сайжруулах зарим боломжууд байгаа.
- ❖ **Санхүүгийн байдал боломжийн ( $60\% < \varpi < 80\%$ )**  
Өрхийн санхүүгийн байдал боломжийн түвшинд хүрсэн ба санхүүгийн зөв шийдвэр, тааламжтай нөхцөл байдал нь санхүүгийн чадамжийг дээшлүүлэх боломжууд бий болсон ч, санхүүгийн буруу шийдвэр, орлогын тасалдал, тааламжгүй өөрчлөлтүүд нь өрхийн санхүүгийн байдлыг тогтворгүй түвшинд хүргэх эрсдэлтэй.
- ❖ **Санхүүгийн байдал сайн ( $80\% < \varpi < 100\%$ )**  
Өрхийн санхүүгийн байдал нь одоогийн улс төр, эдийн засаг, нийгмийн нөхцөл байдалд тааламжтай сайн байгаа. Гэвч гадаад дотоод хүчин зүйлсийн тааламжгүй үйл явдлуудаас үүдэн өрхийн санхүүгийн байдал нь муудах буюу ангилал шилжих магадлалтай.

#### **Ах холбогдол, шинэлэг тал**


Өрхийн санхүүгийн чадамж, үр ашгийн үнэлгээг хийснээр өрхүүдийн амьдралын чанар, санхүүгийн байдлыг шууд дүгнэх боломжтой юм. Энэхүү сэдвийг судалснаар дараах ач холбогдолтой.

- ❖ Өрхийн санхүүгийн бодит байдлыг дүгнэн, санхүүгийн чадамжид нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлсноор цаашид өрхийн санхүүгийн байдлыг дээшлүүлэх боломжийг тодорхойлох
- ❖ Өрхүүд санхүүгийн эрүүл байдлаа хянах, цаашдаа санхүүгийн буруу шийдвэр гаргалт, орлогын тасалдалт нь ирээдүйд ямар эрсдэлд орж болзошгүйг урьдчилан тодорхойлох боломжтой болно.
- ❖ Өрхийн санхүүгийн чадамжийг тооцож, зөвлөмж боловсруулан зөвлөгөө өгснөөр өрхүүдийг санхүүгийн үйлчилгээтэй холбоотой мэдлэг, мэдээллээр хангах, аливаа санхүүгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, оновчтой шийдвэр гаргадаг байх, хувийн болон өрхийн


санхүүгээ удирдах зөв дадал, хэвшилтэй болж өрхүүд орлогоо оновчтой хуваарилах чадвар эзэмшүүлэх

- ❖ Өрхүүдийн санхүүгийн үр ашгийг үнэлснээр орцуудыг бүрэн ашиглаж чадаж байгаа эсэх, цаашдаа санхүүгийн чадамж, үр ашгийг нэмэгдүүлэх боломжтой эсэхийг тодорхойлох юм.
- ❖ Өрхийн санхүүгийн чадамж дээшилснээр иргэдийн амьдралын баталгаа нэмэгдэж, гэр бүлийн аз жаргал, сайн сайхан байдал бий болохоос гадна нийгмийн стресс бухимдал, гэмт хэрэг буурах гэх мэт сөрөг үр дагавруудыг бууруулах сайн талтай.
- ❖ Өрхийн санхүүгийн чадамжийг тооцсоноор инфляци, хүүний түвшин, ханшийн уналт гэх мэт макро эдийн засгийн болон нийгэм, улс төрийн хүчин зүйлсээс хамааран өрхийн санхүү хэрхэн өөрчлөгдөж байгааг тодорхойлох боломжтой болно. Ингэснээр өрхийн санхүүгийн чадамжийг дээшлүүлэх зорилгоор төр засгийн зүгээс бодлогын баримт бичиг боловсруулан, хэрэгжүүлэх боломжтой юм.

### Орхон аймгийн өрхүүдийн санхүүгийн чадамжид хийсэн судалгаа




Уг шинжилгээг хийхдээ Орхон аймгийн Баян-Өндөр сумын өрхүүдээс 95%-ийн магадлалын түвшинд санамсаргүй түүврийн аргаар 597 өрхийг сонгон авч өрхийн санхүүгийн чадамжийг тооцсон. Уг тооцооллыг хийхдээ HFWI аргачлалд үндэслэсэн.



Судалгаанд хамрагдсан нийт 597 өрхийн мэдээлэлд үндэслэн өрхийн санхүүгийн байдлын индексийг тооцоход 1.04% нь санхүүгийн хямралд орсон. Гадны тусламж шаардлагатай, 21.7% нь санхүүгийн байдал тогтворгүй буюу санхүүгийн хямралд ороход бэлэн байгааг илтгэж байгаа бол 54.32% нь санхүүгийн хувьд боломжийн түвшинд хүрсэн ч санхүүгийн буруу шийдвэр, орлогын тасалдалт нь санхүүгийн байдлыг тогтворгүй болгох эрсдэлтэй юм. Харин үлдсэн 22.92% нь одоогийн улс төр, эдийн засаг, нийгмийн нөхцөл байдалд санхүүгийн байдал нь тааламжтай сайн байна. Дэлхийн банкны 2017 онд хийсэн “Монгол улсын ядуурлын түвшин тогтоох судалгаа”-аар Орхон аймгийн ядуурлын түвшин 23.5% гарчээ. Ядуурлын түвшин нь тухайн өрхийн санхүүгийн байдлаас шууд хамааралтай учир бид өөрсдийн тооцсон санхүүгийн чадамжийн индексийг дэлхийн банкны судалгааны үр дүнтэй харьцуулан үзлээ. Бидний тооцсон судалгаагаар Орхон аймгийн судалгаанд хамрагдсан өрхүүдийн 23.1% нь санхүүгийн хувьд хямарсан болон тогтворгүй байна гэж гарсан нь дэлхийн банкны судалгааны үр дүнтэй нийцэж байна.

Зураг 2-т өрхийн санхүүгийн чадамж нь өрхийн тэргүүний боловсролоос хэрхэн хамаарч буйг харуулаа. Өрхийн тэргүүний боловсрол ахихад санхүүгийн чадамж өсч байна. Тухайлбал, Өрхийн тэргүүн бүрэн дунд боловсролтой үед 31.6% нь санхүүгийн хувьд тогтворгүй, 53.9% нь санхүүгийн хувьд боломжийн түвшинд хүрсэн бол 12.8% нь санхүүгийн чадамж сайн болсныг илэрхийлж, өрхийн тэргүүн доктор зэрэгтэй байхад санхүүгийн байдал хямарсан болон тогтворгүй өрх байхгүй ба тухайн өрхүүдийн 33.3% нь санхүүгийн хувьд боломжийн түвшинд, 66.7% нь санхүүгийн чадамж сайн байна.



Ажил эрхлэлтийн байдлаас хамааран санхүүгийн байдлыг судалж үзэхэд Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн ажилчдын санхүүгийн чадамж бусад байгууллагад ажилладаг ажилчдаас өндөр үзүүлэлттэй гарсан нь Эрдэнэт үйлдвэрийн цалингийн хэмжээ бусад байгууллагаас өндөр байдагтай холбоотой.



### Орхон аймгийн өрхүүдийн санхүүгийн үр ашгийг үнэлэх нь

Орхон аймгийн өрхүүдийн санхүүгийн чадамж муу байгаа шалтгааны илрүүлэх, өрхүүдийн орцоо 100% ашиглаж байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор өрхүүдийн санхүүгийн үр ашгийг үнэллээ. Өмнөд африкийн (Momentum, 2017) судалгааны байгууллагаас хийсэн “өрхийн санхүүгийн сайн сайхан байдлын индекс” судалгааны тайланд дурдсанаар өрхүүдийн хүмүүн капитал болон нийгмийн капитал гэсэн орцыг ашиглаж, биет капитал, капиталжсан хөрөнгө, байгалийн капитал гэсэн 3 төрлийн гарцыг бий болгоно гэж үзжээ. Уг орцыг гарц болгох технологи нь өрхийн төсөв, санхүүгийн төлөвлөлт болон зөв шийдвэр гаргалт, санхүүгийн боловсрол, өрийн менежмент, зан төлөвийн өөрчлөлт гэх мэт байна гэж тодорхойлсон. Өөрөөр хэлбэл өрхийн гишүүдийн эзэмшсэн мэдлэг, боловсрол, ажлын туршлага, чадвар (хүмүүн капитал), эрхэлж буй албан тушаал, нийгэмд эзлэх байр суурь, бусдад нөлөөлөх чадвар (нийгмийн капитал) зэрэг орцуудыг ашиглан санхүүгийн төлөвлөлт болон зөв шийдвэр гаргалт, эрсдэлийн төлөвлөгөө, өрийн менежмент, зан төлөвийн өөрчлөлт гэх мэт зүйлсээс хамааран өрхийн төсвийн ашиг, хуримтлал (биет капитал), цэвэр баялаг (капиталжсан хөрөнгө), амьдрах таатай хүрээн буй орчинг (байгалийн баялаг) бий болгодог байна.


Тиймээс үр ашгийн үнэлгээг параметрийн бус DEA аргачлал болон параметрийн стохастик загваруудаар үнэлэхдээ 2 төрлийн орцтой, 3 төрлийн гарцтай гэж үзэн Орхон аймгийн өрхүүдийн түүвэр судалгаанд үндэслэн хийсэн.

### Параметрийн бус DEA аргачлалын үр дүн

Орхон аймгийн өрхүүд санхүүгийн чадамжийг нэмэгдүүлэхийн тулд орцоо бүрэн ашиглаж байгаа эсэх, цаашдаа санхүүгийн чадамжа нэмэгдүүлэх боломжтойг тодорхойлох үүднээс DEA аргачлалаар 597 өрхийн үр ашгийг үнэлэхэд дунджаар 0.63 гарч байгаа нь хангалттай үзүүлэлт биш юм.



Тухайн өрхийн эхнэр болон нөхрийн эзэмшсэн албан боловсролоор нь үр ашгийн арифметик дунжийг тооцож үзэхэд дээд боловсрол эзэмшсэн өрхүүдийн санхүүгийн үр ашиг өндөр гарч байна. Тухайлбал боловсролгүй, бага эсвэл бүрэн дунд боловсролтой өрхүүдийн санхүүгийн үр ашиг дунджаар 65% байхад бакалавр, магистр, докторын зэрэг хамгаалсан өрхүүдийн санхүүгийн үр ашиг дунджаар 76.7% гарсан. Эндээс үзэхэд боловсролын түвшин ахих тусам өрхүүд зээлийн ашиглалт болон өрийн удирдлага сайжирч, санхүүгийн сайн төлөвлөлтийн бий болгосноор санхүүгийн зөв шийдвэр гарган, хэрэглээний зан төлөвт эерэг өөрчлөлт бий болдог байна.



Судалгаанд хамрагдсан 597 өрхийн 255 өрхийн санхүүгийн үр ашиг 40%-аас 60% хүртэл, 294 өрхийнх 60%-наас 80% хүртэл, 39 өрхийнх 80%-наас 100% хүртэл бол 9 өрхийн санхүүгийн үр ашиг 100% гарчээ. Эндээс харвал судалгаанд хамрагдсан 9 өрх орцоо бүрэн ашиглаж гарц болон хувиргаж байхад бусад өрхүүд уг 9 өрхтэй харьцуулахад орцоо бүрэн ашиглаж чадахгүй байна.

Өрхүүдийн санхүүгийн үр ашгийг эхнэр болон нөхрийн эзэмшсэн боловсрол, өрхийн төсвийн ашиг, алдагдал, хадгаламж, өрхийн тэргүүний албан тушаал ахисан эсэх, өрхийн гишүүдийн санхүүгийн боловсролоос нь хамааруулан судлахад хадгаламжтай өрхүүдийн санхүүгийн үр ашиг дунджаар 83.92% байхад хадгаламжгүй өрхүүдийн үр ашиг дунджаар 62.96% гарсан. Харин өрхийн цэвэр баялаг эерэг гарсан өрхүүдийн үр ашиг нь 63% бол цэвэр баялаг нь сөрөг гарсан өрхүүдийн үр ашиг 65.96% гарсан нь өрхүүдийн дийлэнх нь баялагтай болгохын тулд банк болон банк бус санхүүгийн бусад байгууллагаас зээл (судалгаанд хамрагдсан өрхүүдийн 67% нь зээлтэй) авдаг. Уг зээлийн эргэн төлөлт нь өрхүүдийг санхүүгийн хүндрэлд оруулдаг нь цэвэр баялаг эерэг гарсан өрхүүдийн үр ашиг сөрөг гарсан өрхүүдээс бага гарсан шалтгаан болж байна.

## Дүгнэлт

Дэлхийн эдийн засаг, санхүүгийн хөгжил, техник, технологийн дэвшил даяарчлагдаж байгаа өнөө үед дэлхийн улсуудын санхүү, эдийн засаг бие биенээсээ хамааралтай болж, санхүүгийн төрөл бүрийн эрсдэлийг нэмэгдүүлж байгаа нь өрхүүд санхүүгийн шийдвэр гаргахад улам бэрхшээлтэй болж байна.

Өрхийн санхүүгийн байдлаас тэдний бий болгох баялаг, амьдралын сайн сайхан байдал шууд хамаарах учир өрхийн санхүүгийн чадамжийг тооцож, үнэлэх зайлшгүй шаардлагатай.

Тиймээс бид энэхүү судалгаагаар Орхон аймгийн өрхүүдийн санхүүгийн чадамжийг HFWI индексээр тооцоход 1.04% нь санхүүгийн чадавхгүй буюу “хямарсан”, 21.7% нь санхүүгийн хувьд “тогтворгүй”, 54.32% нь санхүүгийн хувьд “боломжийн” түвшинд хүрсэн ч, санхүүгийн буруу шийдвэр, богино хугацааны орлогын тасалдалтаас шалтгаалан санхүүгийн байдал “тогтворгүй” болох эрсдэлтэй, 22.95% нь санхүүгийн байдал “сайн” гэсэн үр дүн гарлаа. Уг тооцооллын үр дүн Орхон аймгийн ядуурлын түвшинтэй нийцэж байгаа нь өрхийн санхүүгийн чадамжийг тооцож буй HFWI аргачлал өрхийн санхүүгийн чадамжийг тооцоход тохиромжтой байгааг харуулж байна.

Орхон аймгийн 21 багаас өрхийн санхүүгийн чадамж хамгийн өндөртэй баг нь Хүрэнбулаг (80.5%) баг байсан бол хамгийн бага гарсан баг нь Наран баг (57.24%) байна.

Судалгаанд хамрагдсан өрхүүдийн үр ашгийг тооцоход 597 өрхийн 255 өрхийн санхүүгийн үр ашиг 40%-аас 60% хүртэл, 294 өрхийнх 60%-иас 80% хүртэл, 39 өрхийнх 80%-иас 100% хүртэл бол 9 өрхийн санхүүгийн үр ашиг 100% гарчээ. Эндээс харвал судалгаанд хамрагдсан 9 өрх орцоо бүрэн ашиглаж гарц болон хувиргаж байхад бусад өрхүүд уг 9 өрхтэй харьцуулахад орцоо бүрэн ашиглаж чадахгүй байна.

Өрхийн санхүүгийн үр ашиг нь өрхийн гишүүдийн боловсрол, албан тушаал, өрхийн төсвөөс шууд хамааралтай байна.

Цаашдаа өрх тус бүрт уг тооцооллыг хийж, зөвлөмж боловсруулснаар Орхон аймгийн өрхүүдийн санхүүгийн чадамж өсөх боломжтой юм.

Тухайн өрхийн амьдралын чанар, аз жаргал, өрх гэрийн сайн сайхан байдал нь тэдний санхүүгийн чадамжаас шууд хамаардаг тул тодорхой хугацааны давтамжтайгаар HFWI индексийг тооцож, мэдээллийн сан үүсгэснээр нийгэм, эдийн засгийн өөрчлөлт бүрд өрхийн санхүүгийн чадамжид шинжилгээ хийж, төр засгийн зүгээс бодлого боловсруулах боломжтой болох юм.

### Ашигласан материал

- [1] Монголбанк, Судалгаа, статистикийн газар, судалгааны хэлтэс. (2016 он оны 6 сар). Нийгэм эдийн засаг, өрхийн амьжиргааны түүвэр судалгаа. Улаанбаатар хот.
- [2] World bank. (2017). *2016 Poverty Rate in Mongolia Estimated at 29.6 Percent* . [www.worldbank.org: http://www.worldbank.org/en/news/press-release/2017/10/17/2016-poverty-rate-in-mongolia-estimated-at-296-percent](http://www.worldbank.org: http://www.worldbank.org/en/news/press-release/2017/10/17/2016-poverty-rate-in-mongolia-estimated-at-296-percent)
- [3] Barwell, R., May, O., & Pezzini, S. (2006). The Distribution of Assets, Income and. *University of Copenhagen, Department of Economics*.
- [4] Berkowitz, M., & Qiu, J. (2006). A Further Look at Household Portfolio Choice. *Journal of Banking and Finance*.
- [5] Cantril, H. (1965). The pattern of human concerns. *New Brunswick, NJ: Rutgers University press*.
- [6] Daniel, G. (2013). Household Finances, Well-Being and Subjective Financial Situation: An Empirical Analysis of Household Survey Data. Australia.
- [7] Ferrer, S. (2005). Income and Well-Being: An Empirical Analysis of the. *Journal of Public Economics, 89(5-6)*.
- [8] Garman, E., & Porter, N. (1993). *Testing a Conceptual Model of Financial Well-Being*. <http://citeseerx.ist.psu.edu/viewdoc/download?doi=10.1.1.379.6832&rep=rep1&type=pdf>-ээс Гаргасан
- [9] Hamburger, M. J. (1968). Household Demand for Financial Assets. *Econometrica*.
- [10] Momentum. (2017). *Household financial wellness index*. Өмнөд Африк.
- [11] Momentum Co.,LTD. (2011). *THE MOMENTUM HOUSEHOLD FINANCIAL WELLNESS INDEX*.
- [12] Strumpel, B. (1976). Economic means for human needs. *Ann Arbor: Institute for Social*.